

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга хурандаа Ч.Энхбаяр
2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт хувь
Зорилт 1. “Батлан хамгаалах бодлого, хууль тогтоомжийг сурталчлах, хэрэгжилтийг зохион байгуулах”							
1.1	Батлан хамгаалах бодлого, зорилт, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг аймгийн иргэд, хөдөлмөрчид, цэргийн насны залуучуудад сурталчилах	Тоо: 5 Чанар: Батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааны хуваарийн дагуу зохион байгуулж иргэдийн 25 хүртлэх хувийг хамруулах	Иргэдийн 20 хүртэлх хувийг хамруулсан	Иргэдийн 22 хүртэлх хувийг хамруулна	Батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааг олон түмэнд хүргэх, нийгэмд Зэвсэгт хүчний нэр хүндийг өсгөх, өсвөр үе хүүхэд залуучуудын бие бялдар, ур чадварыг хөгжүүлэх, цэрэг эх оронч хүмүүжил олгох, бие бялдрын өв тэгш хөгжилтэй залуу хойч үеийг төлөвшүүлэх, иргэн цэргийн харилцааг хөгжүүлэх, цэргийн насны залуусын боловсрол, эрүүл мэндийг дээшлүүлэх, салбарын хууль тогтоомжийг сурталчлах, иргэдийг цэргийн гэрээт албанд элсүүлэх зэрэг ажилд онцгой анхаарал хандуулан ажилласан. 2025 оны хагас жилийн байдлаар батлан хамгаалах салбарын мэдээ мэдээллийг ил тод, нээлттэй хүргэх ажлын хүрээнд аймгийн ЗДТГ, орон нутгийн хэвлэл мэдээлэл, Цэргийн штабын цахим хуудсанд байршуулж нийт иргэдийн 16 хувьд мэдээ мэдээллийг хүргээд байна.	2025.02.01 2025.12.29	100%
1.2	Батлан хамгаалахын хууль тогтоомж, тушаал, шийдвэр, албан даалгаврын хэрэгжилтийг хангаж	Иргэдийн эрх зүйн мэдлэг дээшилсэн байх	Хууль тогтоомжийн хэрэгжилтийг сурталчлах ажлыг жилд 4 удаа зохион байгуулсан	Хууль тогтоомжийн хэрэгжилтийг сурталчлах ажлыг жилд 4 удаа зохион байгуулах	“Монгол Улсын Батлан хамгаалахын бодлогын үндэс” баримт бичиг, батлан хамгаалах суурь хуулиуд, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг аймгийн иргэдэд сурталчлан таниулах, орон нутгийн хамгаалалтын тогтолцоог төгөлдөржүүлэхэд, хяналт тавин ажиллаж байна. Батлан хамгаалахын сайдын 2025 оны 01 дүгээр, Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 1в/1631 албан даалгаврын дагуу “Монгол цэргийн өдөр” Зэвсэгт хүчний 104 жилийн ойг тохиолдуулан “Эх оронч Монгол-Их сэргэлтийн жил”-ийн нээлтийн арга	2025.02.01 2025.12.29	100%

					хэмжээг зохион явуулсан. Тус арга хэмжээний хүрээнд: - Орхон аймаг дахь Их, дээд сургууль, Политехник коллеж болон Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн оюутан, сурагчдад "Эх орон танаа" урлагийн тоглолтыг нийт 650 хүүхэд залуучуудад үзүүлсэн. - Зэвсэгт хүчний 110, 186 дугаар ангиудад хугацаат цэргийн алба хааж байгаа дайчдыг ар гэрийн хамт "Хөх төрийн бэрс" түүхэн жүжгийг нийт 200 хүнд үзүүлсэн. - "Монгол цэргийн өдөр" Зэвсэгт хүчний 104 жилийн ойг тохиолдуулан Орхон аймгийн төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын нээлттэй хаалганы өдрийг зохион байгуулж нийт 1400 гаруй иргэнд үйлчилгээ үзүүлсэн. - Аймгийн Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд "Эх оронч үзэл-Үндэсний бахархал" сэдэвт эсээ бичгийн уралдааныг 2 үе шаттайгаар зохион байгуулсан. "Эх оронч Монгол-Их сэргэлтийн жил"-ийн нээлтийн арга хэмжээний хүрээнд цэрэг эх оронч, үндэсний бахархалт үзлийг төлөвшүүлэх, иргэн цэргийн харилцааг бэхжүүлэх, батлан хамгаалах бодлого, зэвсэгт хүчний үйл ажиллагааг сурталчлах ажлыг хийж гүйцэтгэсэн. Мөн цэргийн үүрэгтэн болон техникийн бүртгэлийг хөтлөх, цэргийн гэрээт алба болон цэргийн дүйцүүлэх албанд элсүүлэх, дайчилгааны бэлтгэл нөөцийг давтан бэлтгэх сургалтыг зохион байгуулж, цэргийн албыг биеэр болон мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах журмын хэрэгжилтийг ханган 2025 оны хагас жилийн байдлаар 700 гаруй иргэнд батлан хамгаалах чиглэлээр төрийн үйлчилгээг үзүүлсэн.		
1.3	Багийн Засаг дарга нарын "Цэргийн бэлтгэл" сургалтыг зохион байгуулах	Багийн Засаг дарга нарын мэдлэг, чадвар дээшилж чадавх нэмэгдсэн байх	Багийн Засаг дарга нарын "Цэргийн бэлтгэл" сургалтыг 1 удаа зохион байгуулсан	Багийн Засаг дарга нарын "Цэргийн бэлтгэл" сургалтыг 1 удаа зохион байгуулна	Дайчилгааны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын Батлан хамгаалах зарим чиг үүргийг Орхон аймагт төлөөлөн 2025 онд хэрэгжүүлэх гэрээний 1.3 дахь заалт, аймгийн Засаг даргын 2025 оны А/280 дугаар захирамж, Цэргийн штабын 2024-2025 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу 2025 оны 04 дүгээр 10-	2025.04.10 2025.04.12	100%

					12-ны өдрүүдэд аймгийн Засаг даргын Тамгын газрын А.Амарын танхим болон Орхон аймаг дахь батлан хамгаалахад туслах нийгэмлэгийн сургалтын материаллаг баазыг түшиглэн цэргийн бэлтгэл сургалтыг 3 хоногийн хугацаатай нийт 96 цаг, жилд 24 цагийн багтаамжтайгаар өдрийн 8 цаг, 1 цаг нь 45 минут байхаар төлөвлөж, батлагдсан хөтөлбөрийн дагуу "Аюулгүй байдлын үндэс" 3 цаг, "Батлан хамгаалах бодлого, эрх зүй" 3 цаг, "Цэргийн албаны тухай ойлголт" 3 цаг, "Дайчилгааны бэлтгэл" 2 цаг, "Орон нутгийн хамгаалалт" 9 цаг, "Цэргийн ерөнхий бэлтгэл" 4 цаг гэсэн 6 хичээлийн хүрээнд нийт 24 цагийн сургалтыг лекц, дадлага, хэлэлцүүлэг, бүлгийн дасгал хэлбэрээр зохион явуулж, сургалтад Баян-Өндөр сумын Засаг даргын Тамгын газрын дарга, баг хариуцсан мэргэжилтэн, багийн Засаг дарга нар 28, Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын дарга, багийн Засаг дарга нар 3 нийт 32 хүний бүрэлдэхүүнтэй багийн Засаг дарга нарын цэргийн бэлтгэл сургалтыг зохион явуулсан. Багийн Засаг дарга нарын цэргийн бэлтгэл сургалтад удирдлагын төлөвлөлтийн баримт бичгүүдтэй танилцуулах, холбогдох хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах, уялдаа холбоог сайжруулах талаар хэлэлцүүлэг зохион байгуулсан нь сургалтад оролцогчдын дутуу ойлголттой байсан асуудлыг бүрэн дүүрэн ойлголт өгч цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлсон нь ололтой тал байлаа.		
1.4	Аймгийн нутаг дэвсгэрт байрлах тусгай хэрэгцээний газарт "Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага, салбарын тусгай хэрэгцээний газарт хориотой бүс тогтоох журам"-ыг мөрдөж ажиллах	Журмын хэрэгжилтийг хангасан байх	Журмын хэрэгжилтийг хангасан	Журмын хэрэгжилтийг хангах	Аймгийн нутаг дэвсгэрт байрлах тусгай хэрэгцээний газарт "Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага, салбарын тусгай хэрэгцээний газарт хориотой бүс тогтоох журам"-ыг мөрдлөг болгон Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн хадгалалтын агуулахуудыг тусгай хэрэгцээний газарт хамааруулж хориотой бүс тогтоон ажиллаж байна.	2025.01.02 2025.12.31	100%
1.5	"Монгол цэргийн өдөр", Зэвсэгт хүчний 104 жилийн ой, Халхын голын байлдааны ялалтын 86 жилийн ой, Чөлөөлөх дайны ялалтын 80 жилийн ойн баярын арга хэмжээг тусгай төлөвлөгөөгөөр зохион байгуулах	Тоо: 2 Чанар: Арга хэмжээг тогтоосон хугацаанд зохион байгуулах	Төлөвлөсөн арга хэмжээг зохион байгуулсан	Төлөвлөсөн арга хэмжээг зохион байгуулсан байх	Монгол Улсын Засгийн газрын Батлан хамгаалахын зарим чиг үүргийг Орхон аймагт төлөөлөн 2025 онд хэрэгжүүлэх гэрээ, аймгийн Засаг даргын 2025 оны А/192 дугаар захирамжийн дагуу тусгай хөтөлбөр, төлөвлөгөө гарган дараах арга хэмжээг шат дараатай зохион байгууллаа. Үүнд - "Монгол цэргийн өдөр" Зэвсэгт хүчний 104 жилийн ойг тохиолдуулан аймгийн Засаг	2025.03.01 2025.03.19	100%

					даргын нэрэмжит "Марш-тусгай бэлтгэлийн аварга тасаг" шалгаруулах цогцолбор тэмцээнд төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын 11 баг тамирчид оролцож нийт 132 алба хаагч хурд, хүч авхаалж самбаагаа сорин өрсөлдсөн. - Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын удирдлагын дундах багийн буудлагын тэмцээн. - Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч нарын дундах богино, урт бууны буудлагын тэмцээн. - Нутгийн удирдлагын ордны албан хаагчдын дунд зохион явуулсан багийн буудлагын тэмцээн. - Аймаг, сумын цолтой хүчид 64 бөхийн барилдаан. - Их, дээд сургууль болон Политехник коллежийн оюутан, сурагчдын дунд "эсээ бичлэгийн уралдаан. - Халхын голын 1939 оны байлдааны ялалтын 86 жилийн ойд зориулан Ерөнхий боловсролын дунд ангийн сурагчдын дунд гар зургийн уралдаан. - 1945 оны чөлөөлөх дайны 80 жилийн ойг тохиолдуулан Ерөнхий боловсролын сургуулиудын ахлах ангийн сурагчдын дунд спорт буудлагын тэмцээн. - 1945 оны чөлөөлөх дайнд оролцсон ахмад дайчин Гончигийн Дугаржав болон Цэргийн штабаас бэлтгэл, чөлөөнд гарсан ахмадуудад хүндэтгэл үзүүлсэн. "Монгол цэргийн өдөр" Зэвсэгт хүчний 104 жилийн ойд зориулсан баярын нэгдсэн хурал, нэгдсэн тооллогыг "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын Соёл урлагийн цогцолборын их танхим болон А.Амарын талбайд ёслол төгөлдөр зохион явуулсан.		
1.6	Аймгийн Ерөнхий боловсролын сургуулиудын ахлах ангийн сурагчдын дунд аймгийн Засаг даргын нэрэмжит Цэрэг спортын "Дөл" цогцолбор тэмцээнийг зохион байгуулах, шалгарсан баг тамирчдыг Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн	Тоо: 1 Чанар: оролцоо чадавх байх ЕБС-уудын нэмэгдэж дээшлэсэн	Боловсруулалт хийгдсэн	Ерөнхий боловсролын сургуулийн 80 хүртлэх хувийг оролцуулах	Аймгийн Засаг даргын 2025 оны А/399 дүгээр захирамжийн дагуу аймгийн Засаг даргын нэрэмжит цэрэг-спортын "ДӨЛ" цогцолбор тэмцээнийг 2025 оны 05 дугаар сарын 24, 25-ны өдрүүдэд Эрдэнэт спорт амралтын хүрээлэнд амжилттай зохион байгууллаа. Тус тэмцээнд 10 сургуулийн 130 сурагч хурд, хүч, авхаалж самбаа, мэдлэг чадвараа сорин гарааны өмнөх ажиллагаа буюу марш гүйлт гэсэн 2 үе шаттай 9	2025.05.01 2025.06.09	100%

	ивээл дор зохион байгуулагдах Батлан хамгаалахын сайдын нэрэмжит улсын аварга шалгаруулах цэрэг-спортын "Дөл-2025" цогцолбор тэмцээнд оролцох				төрлийн норматив, даалгавар биелүүлэн өрсөлдөж тэмцээний нийлбэр дүнгээр: "Тэргүүн байрт"-т Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль шилжин явах цом, алтан медаль, өргөмжлөл, мөнгөн шагнал, "Дэд байрт"-т Ерөнхий боловсролын 14 дүгээр сургууль мөнгөн медаль, өргөмжлөл, мөнгөн шагнал, "Гутгаар байрт"-т Ерөнхий боловсролын 2 дугаар сургууль хүрэл медаль, өргөмжлөл мөнгөн шагнал, "Тусгай байр"-т Ерөнхий боловсролын 13, 4 дүгээр сургуулиуд өргөмжлөл мөнгөн шагналаар тус тус шагнагдсан байна. Мөн Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн нэрэмжит улсын аварга шалгаруулах цэрэг-спортын "Дөл-2025" цогцолбор тэмцээнд аймаа төлөөлөн оролцсон баг тамирчид 12 дугаар байранд орсон.		
1.7	"Хүүхэд залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх" цэргийн насны болон өсвөр насны иргэдийн дунд цэрэг-эх оронч хүмүүжил олгоход чиглэсэн арга хэмжээ зохион байгуулах;				Батлан хамгаалах салбарын хэмжээнд 2025 оныг "Эх оронч Монгол-Их сэргэлтийн жил" болгон зарласантай холбогдуулан хагас жилийн байдлаар дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд - "Монгол цэргийн өдөр" Зэвсэгт хүчний 104 жилийн ойг тохиолдуулан "Эх оронч Монгол-Их сэргэлтийн жил"-ийн нээлтийн арга хэмжээг Монгол Улсын баатар "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын Соёл урлагийн цогцолборын их танхимд төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагууд, Орхон аймагт амьдарч, ажиллаж байгаа тэтгэвэрт, чөлөөнд байгаа ахмадууд, оюутан, сурагчид, хугацаат цэргийн алба хааж буй дайчдын ар гэрийн төлөөлөл оролцсон. - Монгол Улсын баатар "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын Соёл урлагийн цогцолборын Эрдэнэт дуу бүжгийн чуулгатай хамтран хүүхэд залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх зорилгоор "Эх орон танаа" түүхчилсэн тоглолтыг Эрдэнэт цогцолбор дээд сургууль, Политехник коллеж, Ерөнхий боловсролын ахлах ангийн сурагчдад үнэ төлбөргүй үзүүлсэн. - Өсвөр насны иргэдийн дунд цэрэг-эх оронч хүмүүжил олгоход чиглэсэн арга хэмжээний ажлын хүрээнд "Эх орны дуудлага" 18 нас хүрсэн иргэнд цэргийн үүрэгтний үнэмлэх гардуулах ёслолын арга хэмжээг зохион явуулсан.	2025.03.01 2025.11.25	100%

					Орхон аймгаас 2024 оны II ээлжээр хугацаат цэргийн жинхэнэ албанд татагдан Зэвсэгт хүчний 110, 186 дугаар ангиудад алба хааж байгаа дайчдыг ар гэрийн хамт Хүүхэд залуучуудын театрт “Хөх төрийн бэрс” түүхэн жүжгийг үзүүлсэн нь иргэн цэргийн харилцаа, анги байгууллагын нээлтэй ил тод байдлыг харуулсан арга хэмжээ болсон.		
1.8	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын алба хаагчдын ажиллаж, амьдрах нөхцөлийг сайжруулах, эрүүл мэндийн урьдчилсан үзлэгт хамруулах.	Ажиллаж, амьдрах нөхцөлийг сайжруулах, эрүүл мэндийн урьдчилсан үзлэгт хамруулах	Эрүүл мэндийн үзлэгт 1 удаа хамруулсан	Эрүүл мэндийн үзлэгт 1 удаа хамрагдаж эрүүл мэндийн түвшинг тогтооно	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын алба хаагчдын ажиллах нөхцөл бололцоог сайжруулах үүднээс албаны зөөврийн компьютер, тоног төхөөрөмжийг шинэчилсэн. Эрүүл мэндийн үзлэг 2025 оны IV улиралд хамрагдана.	2025.09.01 2025.11.01	Хугацаа хүлээгдэж байгаа
Зорилт 2. “Цэргийн бүртгэл, цэрэг халалт, татлага зохион байгуулах, цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж байгаа иргэдтэй сургалт явуулах, мөнгөн төлбөрийн тооцоо хийх”							
2.1	Цэргийн бүртгэлийг хөтлөх, зохион байгуулах	Цэргийн бүртгэлийг тогтоосон хугацаанд 1 удаа хамрагдвал зохих иргэдийн 90-ээс дээш хувийг хамруулах	Хамрагдвал зохих иргэдийн 90 хувь нь хамрагдсан	Хамрагдвал зохих иргэдийн 90-ээс дээш хувийг хамруулна	2025 оны Цэргийн шинэчилсэн бүртгэл аймгийн Засаг даргын 2024 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/804 дүгээр захирамжийн дагуу 2024 оны 12 дугаар сарын 25-наас 2025 оны 01 дүгээр сарын 24-ний хооронд цахимаар болон цаасан суурьтайгаар явагдлаа. Аймгийн хэмжээнд цэргийн 90.7 хувьтайгаар явагдлаа. E-mongolia цахимаар 2897 хүсэлт ирснийг хүлээн авч шийдвэрлэлээ. Цэргийн шинэчилсэн тоо бүртгэлийн нэгдсэн дүн, мэдээг нэгтгэн ЗХЖШ-ын БСТГ-т хүргүүлсэн.	2025.12.25 2025.01.24	100%
2.2	Хугацаат цэргийн албаны цэрэг халалт, татлагыг зохион байгуулах	Тоо: 2 Чанар: Хуулийн дагуу хугацаат цэргийн хаалгах	Хяналтын тоог 100 хувь биелүүлсэн	Хяналтын тоог 100 хувь биелүүлнэ	Аймгийн Засаг даргын 2025 оны А/310 дугаар захирамжийн дагуу 2024 оны I ээлжээр татагдсан цэргүүдийг хүлээн авах, 2025 оны I ээлжийн цэрэг татлагын ажлыг зохион байгуулах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. 2025 оны 05 дугаар сарын 24, 25-ны өдрүүдэд I ээлжийн цэрэг татлагын эрүүл мэндийн үзлэгийг зохион байгуулж, 2025 оны 05 дугаар сарын 04-ний өдөр Хилийн цэргийн төв дамжинд хүргэж, хүлээлгэн өгсөн. Ээлжит цэрэг татлагууд зохион байгуулсан тухай холбогдох мэдээ тайланг маягтын дагуу боловсруулан БХЯ, ЗХЖШ-ын холбогдох газар, хэлтсүүдэд хүргүүлсэн.	2025.05.10 2025.05.04	100%
2.3	Цэргийн гэрээт албыг иргэдэд сурталчлах, элсүүлэх ажлыг цэргийн анги,	Тоо: 1 Чанар: Журмын хэрэгжилтийг хангах	Гэрээт цэргийн тоог 2-оор нэмэгдүүлсэн	Гэрээт цэргийн тоог 2-аар нэмэгдүүлнэ	Цэргийн албаны тухай хуулийн 8 дугаар зүйл, “Цэргийн албыг сайн дурын үндсэн дээр гэрээгээр хаах журам”-ын дагуу цэргийн жинхэнэ алба хаах	2025.05.01 2025.10.20	100%

	байгууллагатай хамтран зохион байгуулах				хугацаа дуусч бэлтгэлээр халагдсан иргэдийг ажлын байраар хангах, гэрээт албанд сайн дурын үндсэн дээр элсүүлэх ажлыг зохион байгуулж байна. Хугацаат цэргийн алба хаасан залуучуудыг журмын дагуу цэргийн гэрээт албанд сонгон, хууль хяналтын байгууллагатай хамтран гэмт хэрэгт холбогдсон эсэхийг шалгуулж, ёс суртахууны зөв төлөвшилттэй иргэдийг сонгон Зэвсэгт хүчин, Хилийн ба, Дотоодын цэргийн анги салбаруудтай хамтран ажиллаж байна. 2025 оны хагас жилийн байдлаар Зэвсэгт хүчний анги салбаруудад цэргийн гэрээт алба хаагч 5, Хилийн цэрэгт гэрээт хилчнээр 6, Дотоодын цэргийн анги салбарт мэргэжлийн боловсрол олгох сургалтад 1, нийт 12 иргэн ахлагчийн алба болон цэргийн гэрээт албыг сайн дурын үндсэн дээр хаах хүсэлт гаргаад байна.		
2.4	Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж байгаа иргэдийн сургалтыг зохион байгуулах	Тоо: 1 Чанар: Томилгоот үүрэг гүйцэтгэх дадлага чадварыг нэмэгдүүлэх	Сургалтыг жилд 1 удаа зохион байгуулсан	Сургалтыг 1 удаа зохион байгуулах	2025 оны I ээлжийн цэрэг татлагын товчооны гаргасан шийдвэрийн дагуу II улирал буюу 06 дугаар сарын 27-ноос зохион явуулахаар төлөвлөн ажиллаж байна.	2025.06.27 2025.07.09	Хугацаа хүлээгдэж байгаа
2.5	"Оюутан цэрэг"-т цэргийн мэргэжил олгох сургалтыг зохион байгуулах	Хуулийн дагуу цэргийн хаалгах алба	"Оюутан-цэрэг" цэргийн сургалтыг зохион байгуулсан	"Оюутан-цэрэг" цэргийн сургалтыг 1 удаа зохион байгуулна	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 85 дугаар тогтоол, Батлан хамгаалахын сайдын 2025 оны А/43 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2025 оны А/255 дугаар захирамжийн дагуу Оюутан цэрэг сургалтын Цэргийн ерөнхий бэлтгэл шатны онолын сургалтыг аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабын сургалтын танхимд зохион явуулса. 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдрөөс цэргийн мэргэжлийн бэлтгэл шатны сургалт эхэлнэ.	2025.03.01 2025.08.15	100%
2.6	Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах болзлыг хангасан иргэдийн төлбөр төлөлтөд хяналт тавих, бүртгэл тооцоог хөтлөх	Тоо:1 Чанар:Хуулийн дагуу цэргийн албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах	Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэдийн төлбөрийг 100 хувь барагдуулна	Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэдийн төлбөрийг 100 хувь барагдуулсан	2025 оны I улирлын байдлаар цэргийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн 130 иргэнийг Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаалгаж, мөнгөн төлбөрийн орлого 252,351,006 сая төгрөгийг төв төрийн сангийн дансанд төвлөрүүлээд байна.	2025.01.01 2025.05.31	100%
2.7	Цэргийн насны залуусын шилжилт хөдөлгөөнд хяналт тавих	Тоо:1 Чанар: Орон нутагт завсардах байдал багасах	Шилжилт хөдөлгөөнд хяналт тавьж, бүртгэлжүүлнэ	Шилжилт хөдөлгөөнд хяналт тавьж бүртгэлжүүлсэн	Аймгийн Улсын бүртгэлийн хэлтэстэй хамтран цэргийн насны залуучуудын шилжилт хөдөлгөөнд хяналт тавих ажлыг зохион байгуулж байна. Нэгдүгээр байдлаар Улаанбаатар хот болон өөр аймаг руу шилжсэн 18-50 насны 15, шилжиж ирсэн 20 иргэн бүртгэгдсэн байна.	2025.01.01 2025.05.31	100%

2.8	Цэргийн насны залуусыг эрүүлжүүлэх талаар удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах, үр дүнг нь тооцох	Цэргийн насны залуучуудыг эрүүлжүүлж хуулийн дагуу хугацаат цэргийн алба хаалгах	Цэргийн насны иргэдийг эрүүлжүүлэх арга хэмжээ авч ажилласан	Цэргийн насны иргэдийг эрүүлжүүлэх арга хэмжээ авч ажиллана	Засгийн газрын 2024 оны 140 дүгээр тогтоолоор батлагдсан "Иргэнийг цэргийн жинхэнэ албанд эрүүл мэндээр тэнцүүлэх болон цэргийн алба хаагчдын эрүүл мэндийн байдлыг тодорхойлох журам"-ыг баримтлан 2024 оны II, 2025 оны I ээлжийн цэрэг татлагын үзлэгээр эрүүл мэндээр тэнцэхгүй дүгнэлттэй гарсан боловч эмчлэгдэх боломжтой 18-25 насны нийт 17 иргэнийг эрүүл мэндийн түвшин дээшлүүлэх, эрүүлжүүлэх ажлыг Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, өрхийн эмнэлгүүдийн хяналтад авч бүртгэл хийн, эмчилгээ хийгдсэн.	2025.01.01 2025.12.25	100%
2.9	Хугацаат цэргийн алба хааж буй дайчдын цэргийн албаны үйл ажиллагаатай танилцах, тэдний ар гэрт нь дэмжлэг, туслалцаа үзүүлэх	Хугацаат цэргийн алба хааж буй дайчдын ар гэрт туслалцаа үзүүлэх	Хугацаат цэргийн алба хааж буй дайчдын ар гэр 20 хүртэлх хувьд туслалцаа үзүүлсэн	Хугацаат цэргийн алба хааж буй дайчдын ар гэр 20 хувьд туслалцаа үзүүлэх	Орхон аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб нь хагас жилий байдлаар Зэвсэгт хүчний 110, 186 дугаар ангиуд, Хилийн цэргийн 0277, 0311, 0245 дугаар ангиудад 2024 оны I, II ээлжээр хугацаат цэргийн албанд татагдсан дайчдаа иргэж анги байгууллагад тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэн дэмжлэг үзүүлэн ажилласан. Үүнд Зэвсэгт хүчний 186 дугаар анги - Цэргийн байрны 00 өрөөний өргөтгөлд шаардагдах зардал - Соёлын төвийн сандал 200 ширхэг - Ангийн явган зам, машин замын бетон хашлаг /бродюр/ 1200 ш - Үлээвэр найрал хөгжмийг шинэчлэн солих. Хилийн цэргийн 0277 дугаар анги - 4х6 хэмжээтэй хүлэмж 5 ширхэг - Фитнес тоног төхөөрөмж 5 төрөл. Хилийн цэргийн 0311 дүгээр анги - 4х6 хэмжээтэй хүлэмж 2 ширхэг - Цөцгий ялгах цахилгаан машин 1 ширхэг. Хилийн цэргийн 0245 дугаар анги - 4х6 хэмжээтэй хүлэмж 2 ширхэг - Махны цахилгаан машин 1 ширхэг. Нийт хөрөнгө оруулалт 147 сая гаруй төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн.	2025.01.05 2025.12.25	100%
Зорилт 3. "Дайчилгааны төлөвлөгөөг тодотгох, даалгаваржуулах, дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний сургалтыг зохион байгуулах"							
3.1	Аймгийн дайчилгааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, сумдын дайчилгааны төлөвлөгөөг боловсруулах, аймгийн Засаг даргаар батлуулах	Тоо: 2 Чанар: Сумдын дайчилгааны төлөвлөгөөг шинэчлэн батлах	"МУЗГ-ын тогтоол"-оор аймгийн дайчилгааны даалгавар батлагдсан	Аймгийн дайчилгааны төлөвлөгөө батлагдаж, сумдын дайчилгааны даалгаврыг	Аймгийн дайчилгааны төлөвлөгөөг үндэслэн Баян-Өндөр, Жаргалант сумдын төлөвлөгөө боловсруулах бэлтгэл ажлыг хангаж байна.	2025.04.02 2025.09.02	Хугацаа хүлээгдэж байгаа

				тогтоосон байна			
3.2	"Зэвсэгт хүчний нэгтгэл, ангийг бие бүрэлдэхүүн, техникээр нөхөн хангах төлөвлөгөө"-ний хэрэгжилтийг хангах, төлөвлөгөөг тодотгож, актыг Зэвсэгт хүчний Жанжин штабт хүргүүлэх; /05, 11 дүгээр сард/	Тоо: 2 Чанар: Холбогдох хууль тогтоомжийн дагуу байна	Нууцын журмын дагуу баримт бичгүүд бүрэн хийгдсэн	Аймгийн дайчилгааны төлөвлөгөөг тодотгосон байна	"Зэвсэгт хүчний нэгтгэл, ангийг бие бүрэлдэхүүн, техникээр нөхөн хангах төлөвлөгөө"-г хагас жилийн байдлаар тодотгол хийж ЗХЖШ-ын холбогдох газарт хүргүүлсэн.	2025.05.01 2025.05.24	100%
3.3	"Цэргийн штабыг байлдааны бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх төлөвлөгөө"-ний хэрэгжилтийг хангах, төлөвлөгөөг тодотгож, актыг Зэвсэгт хүчний Жанжин штабт хүргүүлэх; /05, 11 дүгээр сард/	Тоо: 2 Чанар: Холбогдох хууль тогтоомжийн дагуу байна	Нууцын журмын дагуу баримт бичгүүд бүрэн хийгдсэн	Аймгийн дайчилгааны төлөвлөгөөг тодотгосон байна	"Цэргийн штабыг байлдааны бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх төлөвлөгөө"-г тодотгол хийж, бэлэн байдлын үзлэгийн бэлтгэл ажлыг хангаж байна.	2025.05.01 2025.06.20	100%
3.4	Төрлийн цэргийн командлалаас зохион байгуулсан цэргийн бэлтгэл албаны сургалтад оногдуулан бүртгэгдсэн дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүнийг оролцуулж, бэлтгэл үүрэгтний цэргийн болон цэрэг-техникийн бэлтгэлийг дээшлүүлэх;	Тоо: 2 Чанар: Холбогдох хууль тогтоомжийн дагуу байна	Дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүнийг тодотгосон	Дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүн 50 хүнийг оролцуулсан байна	Батлан хамгаалахын сайдын 2025 оны н/01 дүгээр тушаалын дагуу дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний цэргийн мэргэжил олгох, давшан бэлтгэх сургалтыг 5 хоногийн 40 цагаар Зэвсэгт хүчний 186 дугаар анги дээр зохион явуулсан. Зэвсэгт хүчний 110 дугаар ангийн дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний сургалт III улиралд зохион байгуулагдахаар төлөвлөөд байна.	2025.04.02 2025.09.30	90%
3.5	Нууц баримт бичиг, бусад нууц тээгчийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, бүрэн бүтэн байдалд нэг бүрчлэн тооллого хийж, хадгалалт хамгаалалтын байдал, түүнийг сайжруулах талаар авах арга хэмжээний талаарх санал, дүгнэлтийг тусган акт бичиж нэг хувийг Зэвсэгт хүчний Жанжин штабт хүргүүлэх; /06, 12 дугаар сард/	Тоо: 2 Чанар: Нууц баримт бичиг, бусад нууц тээгчийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, сайжирсан байх	Нууцын журмын дагуу тооллого явуулсан	Нууцын тооллого хийж дүгнэлт, актыг ЗХЖШ-т хүргүүлсэн байна	Монгол Улсын Төрийн болон албаны нууцын тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 246 дугаар тогтоолоор баталсан "Төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журам"-ын 12.4 дэх заалт, "Монгол Улсын Батлан хамгаалахын төрийн болон албаны нууцыг хамгаалах журам"-ын 7 дугаар бүлгийн 7.23 дахь заалтуудыг үндэслэн аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2025 оны А/45 дугаар тушаалаар томилогдсон тооллогын комисс Цэргийн штабт ашиглагдаж байгаа дайчилгааны бэлэн байдлын онц чухал нууц, маш нууц, нууц баримт бичгийн эхний хагас жилийн тооллого, шалгалтыг явуулж, тайлан, мэдээг БХЯ, ЗХЖШ-ын газар, хэлтсүүдэд хүргүүлсэн.	2025.06.09 2025.06.10	100%

3.6	Цэргийн штаб, батлан хамгаалахад туслах олон нийтийн байгууллага хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх	Тоо: 3 Чанар: Хамтын ажиллагааг бэхжүүлэх	Хамтын ажиллагааг 3-аас доошгүй ажил зохион байгуулсан	Төлөвлөсөн төлөвлөгөөт ажил зохион явагдсан байна	2025 оны I улирлын байдлаар "Монгол цэргийн өдөр", Зэвсэгт хүчний 104 жилийн ой, Халхын голын байлдааны ялалтын 86 жилийн ой, 1945 оны чөлөөлөх дайны ялалтын 80 жилийн ойн, цэрэг-спортын "Дөл" цогцолбор тэмцээн гэх мэт арга хэмжээнийүүдийг тусгай төлөвлөгөөний дагуу дараах газруудтай хамтран ажилласан. Үүнд - Батлан хамгаалахад туслах нийгэмлэг; - Боловсролын газар; - "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын Соёл урлагийн газар; Хүүхэд залуучуудын театр гэх мэт байгууллагуудтай хамтран ажилласан.	2025.01.05 2025.12.01	100%
Зорилт 4. "Орон нутгийн хамгаалалтын төлөвлөлт, түүний хэрэгжилтийг хангах, болзошгүй гамшгийн аюулын үед харилцан ажиллах бэлтгэлийг хангах."							
4.1	Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган, томилгоот нэгжийн сургалтыг зохион байгуулах	Тоо: 1 Чанар: Холбогдох хууль тогтоомжийн дагуу	Сургалтыг зохион байгуулсан	Томилгоот нэгжийн бүрэлдэхүүний сургалтыг жил 1 удаа зохион байгуулна	Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн "Удирдах бүрэлдэхүүн"-ний сургалтыг III улиралд зохион явуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна.	2025.08.01 2024.08.10	Хугацаа хүлээгдэж байгаа
4.2	Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөний дагуу томилгоот нэгжүүдэд томилгоожсон бие бүрэлдэхүүнийг тодотгох	Тоо: 1 Чанар: Холбогдох хууль тогтоомжийн дагуу	Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөний дагуу томилгоот нэгжүүдийг жилд 1 удаа тодотгосон байх	Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөний дагуу томилгоот нэгжүүдийг жилд 1 удаа тодотгоно	2025 оны I улиралд Баян-Өндөр, Жаргалант сумдын орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөний дагуу хүн, техник болон галт хэрэгслийг тодотгож нөхөн томилгоожуулсан.	2025.02.01 2025.02.09	100%
4.3	Аймгийн цэрэг-стратегийн үнэлгээг нийгэм, эдийн засгийн статистик үзүүлэлтэд үндэслэн цэргийн ажиллагаанд үзүүлэх нөлөөг бодитойгоор тооцон боловсруулж дүгнэлт гаргах	Тоо: 1 Чанар: Аймгийн цэрэг-стратегийн үнэлгээг нийгэм, эдийн засгийн статистик үзүүлэлтэд нийцүүлэн байна	Аймгийн цэрэг-стратегийн үнэлгээг нийгэм, эдийн засгийн статистик үзүүлэлтэд үндэслэн боловсруулсан	Аймгийн цэрэг-стратегийн үнэлгээг нийгэм, эдийн засгийн статистик үзүүлэлтэд үндэслэн боловсруулна	Хугацаа болоогүй	2025.12.02 2025.12.06	Хугацаа хүлээгдэж байгаа

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.	БД/300 судлах	Бригад, хороо тактикийн ажиллагаа, хориглолт, давшилт	2 багц цаг	Тасаг, салаа, рот тактикийн ажиллагаа, хориглолт, давшилт мэдлэг бататгасан	Ажлын бус цагаар 7 хоногийн 2 өдрийн 80 цагийн хичээлийг бие даан судалсан.	2025.01.05 2025.05.01	100%
2.	Цэргийн мэргэжлийн магистрын зэрэг хамгаалах	Магистрын зэрэг хамгаалсан байна	10 багц цаг	Мэргэжил, ур чадварыг нэмэгдүүлэхэд суралцана.	Нийт 10 багц сургалтад хамрагдаж магистрын ажлын сэдвийн хамгаалалтад орсон.	2025.01.05 2025.05.10	100%

ТАЙЛАН ГАРГАСАН:

Цэргийн штабын дарга
(Албан тушаал)

Хурандаа Ч.Энхбаяр /
(Нэр, гарын үсэг)



2025.06.10
(Огноо)